

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/98/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт .....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
С.АЙГУЛ ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № ᠒᠒᠑  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>102,372,612.99</b>	<b>52,746,217.67</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	581,054.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	581,054.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	101,791,558.99	52,746,217.67
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	156,000.00	331,500.00
35130	Эм боох материал	156,000.00	331,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	101,635,558.99	52,414,717.67
35410	Бичиг хэргийн материал	521,600.00	885,000.00
35420	Аж ахуйн материал	35,284,768.10	8,459,840.00
35430	Сэлбэг хэрэгсэл	610,500.00	610,500.00
35440	Түлш, шатах тослох материал	3,175,542.76	1,694,072.74
35460	Хүнсний материал	35,150,066.07	13,872,222.87
35470	Бусад хангамжийн материал	26,893,082.06	26,893,082.06
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>504,278,555.68</b>	<b>499,732,183.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	504,278,555.68	499,732,183.21
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	480,930,555.68	476,384,183.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	482,345,695.21	478,810,110.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,167,045.42)	(28,729,568.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,364,400.00	15,837,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,191,941.71)	(9,712,546.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,717,693.00	10,368,136.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,655,696.55)	(5,486,900.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,865,561.15	37,353,161.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,348,110.00)	(22,055,408.80)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	23,348,000.00	23,348,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	23,348,000.00	23,348,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>606,651,168.67</b>	<b>552,478,400.88</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,386,616.14</b>	<b>11,259,413.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	14,386,616.14	11,259,413.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	14,386,616.14	11,259,413.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,853,371.14	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	12,533,245.00	11,259,413.00
41361	Байгууллагад төлөх өглөг	12,533,245.00	11,259,413.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>592,264,552.53</b>	<b>541,218,987.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	592,264,552.53	541,218,987.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	158,422,772.00	158,422,772.00
51101	Өмч: - төрийн	158,422,772.00	158,422,772.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	184,772,342.53	133,726,777.88
51210	Өмнөх үеийн үр дүн	184,772,342.53	184,772,342.53
51220	Тайланг үеийн үр дүн		(51,045,564.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,069,438.00	249,069,438.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>606,651,168.67</b>	<b>552,478,400.88</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>588,995,665.00</b>	<b>557,753,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>33,440.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	33,440.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	33,440.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,440.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>588,962,225.00</b>	<b>557,753,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	571,714,925.00	537,497,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	13,461,225.00	600,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	558,253,700.00	536,897,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	17,247,300.00	20,050,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,247,300.00	20,050,600.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>581,348,146.20</b>	<b>608,799,064.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>581,348,146.20</b>	<b>608,799,064.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	578,225,346.20	608,798,664.65
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	449,322,121.14	449,532,082.86
210101	Үндсэн цалин	406,299,108.14	400,177,182.86
210104	Урамшуулал	26,484,713.00	32,816,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,538,300.00	16,538,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,793,600.00	59,819,000.00
210201	Тэтгэврийн даатгал	42,780,600.00	42,094,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,503,200.00	4,431,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,602,600.00	3,544,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	900,700.00	886,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,006,500.00	8,862,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,948,639.00	25,195,648.02
210301	Гэрэл, цахилгаан	965,935.00	2,873,400.00
210302	Түлш, халаалт	21,982,704.00	22,322,248.02
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,738,310.00	31,828,568.10
210401	Бичиг хэрэг	2,378,400.00	146,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	287,500.00	466,000.00
210404	Ном, хэвлэл		40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,072,410.00	31,176,268.10
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25,253,693.56	27,215,708.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		576,500.00
210502	Хоол, хүнс	25,175,213.56	26,639,208.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	78,480.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	188,300.00	501,800.00
210702	Дотоод албан томилолт	188,300.00	501,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	262,500.00	250,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,500.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,718,182.50	14,455,857.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	275,700.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,442,482.50	14,455,857.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,122,800.00	400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,122,800.00	400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,122,800.00	400.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>7,647,518.80</b>	<b>(51,045,564.65)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>7,647,518.80</b>	<b>(51,045,564.65)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,422,772.00	258,722,938.00	169,796,581.81	3.00	586,942,294.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			9,653,500.00		9,653,500.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,422,772.00	258,722,938.00	179,450,081.81	3.00	596,595,794.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,422,772.00	258,722,938.00	179,450,081.81	3.00	596,595,794.81
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,422,772.00	258,722,938.00	179,450,081.81	3.00	596,595,794.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-9,653,500.00	5,322,260.72		-4,331,239.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,422,772.00	249,069,438.00	184,772,342.53	3.00	592,264,555.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-51,045,564.65		-51,045,564.65
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,422,772.00	249,069,438.00	133,726,777.88	3.00	541,218,990.88

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>575,501,000.00</b>	<b>557,153,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>575,501,000.00</b>	<b>557,153,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	558,253,700.00	536,897,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	558,253,700.00	536,897,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	17,247,300.00	20,050,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,247,300.00	20,050,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>575,101,000.00</b>	<b>555,229,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>575,101,000.00</b>	<b>555,229,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>571,978,200.00</b>	<b>555,229,300.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	448,677,610.00	450,804,400.00
210101	Үндсэн цалин	396,966,282.00	401,449,500.00
210104	Урамшуулал	35,173,028.00	32,816,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,538,300.00	16,538,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,793,600.00	59,819,000.00
210201	Тэтгэврийн даатгал	42,780,600.00	42,094,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,503,200.00	4,431,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,602,600.00	3,544,800.00

210204	Ажилгүйдлийн даатгал	900,700.00	886,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,006,500.00	8,862,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,247,300.00</b>	<b>19,840,600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	965,935.00	2,873,400.00
210302	Түлш, халаалт	16,281,365.00	16,967,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,213,300.00</b>	<b>5,687,100.00</b>
210401	Бичиг хэрэг	706,200.00	1,061,700.00
210402	Тээвэр, шатахуун	310,000.00	2,052,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	287,500.00	466,000.00
210404	Ном, хэвлэл	113,000.00	113,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,796,600.00	1,994,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>39,200,140.00</b>	<b>16,039,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	235,000.00	733,500.00
210502	Хоол, хүнс	37,748,700.00	14,189,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,216,440.00	1,116,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>210,000.00</b>
210604	Урсгал засвар		210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>188,300.00</b>	<b>501,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	188,300.00	501,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>344,200.00</b>	<b>2,327,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,200.00	2,077,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,313,750.00</b>	<b>-</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,313,750.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,122,800.00</b>	<b>400.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,122,800.00</b>	<b>400.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,122,800.00	400.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>400,000.00</b>	<b>1,923,800.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>400,000.00</b>	<b>1,923,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>400,000.00</b>	<b>1,923,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>400,000.00</b>	<b>1,923,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	400,000.00	1,923,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(400,000.00)</b>	<b>(1,923,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	556,948,500.00	556,948,100.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	556,948,500.00	556,948,100.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	556,948,500.00	556,948,100.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	450,804,400.00	450,804,400.00
210101	Үндсэн цалин	401,449,500.00	401,449,500.00
210104	Урамшуулал	32,816,600.00	32,816,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,538,300.00	16,538,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,819,000.00	59,819,000.00
210201	Тэтгэврийн даатгал	42,094,900.00	42,094,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,431,100.00	4,431,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,544,800.00	3,544,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	886,200.00	886,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,862,000.00	8,862,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,840,600.00	19,840,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,873,400.00	2,873,400.00
210302	Түлш, халаалт	16,967,200.00	16,967,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,522,600.00	5,522,600.00
210401	Бичиг хэрэг	1,102,200.00	1,102,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,052,300.00	2,052,300.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	466,000.00	466,000.00
210404	Ном, хэвлэл	113,000.00	113,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,789,100.00	1,789,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,039,100.00	16,039,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	733,500.00	733,500.00
210502	Хоол, хүнс	14,189,500.00	14,189,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,116,100.00	1,116,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	210,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	502,200.00	501,800.00
210702	Дотоод албан томилолт	501,800.00	501,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам</b>	2,327,300.00	2,327,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр	2,077,300.00	2,077,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,883,300.00	1,883,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,883,300.00	1,883,300.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	556,948,500.00	556,948,100.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	536,897,900.00	536,897,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	536,897,900.00	536,897,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	20,050,600.00	20,050,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	20,050,600.00	20,050,600.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	48.00	49.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	23.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>49.0</b>	<b>49.0</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	26.00	26.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23.00	23.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>205,000.00</b>
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	-	205,000.00
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	205,000.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	-	205,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	205,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	205,000.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж, хоолны зардалтай холбоотой 4.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тавигдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 582.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54.2 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	581.0	0.00	-581.0
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	101791.5	52746.2	-49045.3
Үндсэн хөрөнгө	504278.5	499732.2	-4546.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>606651.2</b>	<b>552478.4</b>	<b>-54172.8</b>
Өр төлбөр	14386.6	11259.4	-3127.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	592264.5	541218.9	-51045.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>606651.2</b>	<b>552478.4</b>	<b>-54172.8</b>

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна. Авлагын данс оны эхнээс 0.6 сая төгрөгөөр буурсан нь 0.5 сая төгрөгийн татварын авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52.7 сая төгрөг болж 49.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 21.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 18.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Мөн түүнчлэн 29.9 сая төгрөгийн бараа материалыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 54 дугаар тогтоолоор акталж, 23.0 сая төгрөгийн бараа материалыг өнгөрсөн оны аудитаар аймаг дахь Төрийн аудитын

газрын зөрчил арилгуулах албан шаардлагын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр данснаас хассан байна.

Данснаас хассан энэхүү 23.0 сая төгрөгийн бараа материалын 1.3 сая төгрөгийг аж ахуйн материалын дансанд, 7.3 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд залруулга хийж бүртгэсэн, 5.7 сая төгрөгийн зөрчилд Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн акт тавигдсан, 8.7 сая төгрөгийн бараа материалыг цэцэрлэгийн эрхлэгчийн “Эд хөрөнгийг тооллого хийх комисс байгуулах тухай” 2021 оны А/41 тушаалаар байгуулсан жилийн эцсийн тооллогын комиссын 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэл, Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагчийн гаргасан тооцоо, дүгнэлтийг үндэслэн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/47 тоот тушаалаар данснаас хассан байна.

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн тогтоосон дээрх 5.7 сая төгрөгийн актын 3.0 сая төгрөгийн зөрчил нь өмнөх няравтай холбоотой гарсан төлбөрийн акт гэх боловч нотлох баримтыг бүрдүүлж хавсаргаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 499.7 сая төгрөг болж 4.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, акталсан 3 эсгий гэрийг сэлбэж 1 эсгий гэр болгож 0.6 сая төгрөгөөр үнэлж орлого авсан, 29.8 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоолоор акталсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 11.2 сая төгрөг болж өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь 2020 оноос дамжиж ирсэн түлш халаалтын өр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 541.2 сая төгрөг болж 51.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 557.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 31.2 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 27.4 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал өмнөх оноос нэмэгдэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус цэцэрлэгийн 2020 оны анх батлагдсан төсөв 603.3 сая төгрөг, тодотгосон төсөв 556.9 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 46.4 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

Цалингийн зардал 3.7 сая, хангамж, бараа материалын зардал 2.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 1.8 сая төгрөгөөр нэмэгдэж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 0.5 сая, хоолны зардлыг 54.8 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 536.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 536.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөг олгож, байгууллагын ариутгалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Нийт санхүүжилт 556.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 481.1 сая төгрөгийн зардлыг хасахад 75.8 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 7.5 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Тус цэцэрлэгийн төсвийг тодотголоор 46.4 сая төгрөгөөр танасан тул Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан гэх үндэстэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 556.9 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 556.9 сая төгрөгийн 146 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн 35.1 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдлийн тооллого хийгдээгүй, үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй, 14.34 сая өглөгийг шинээр үүсгэсэн, оны эцэст дээрх хэмжээний өр, авлагатай гарсан боловч ажилчдад 7.2 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтөд олгосон зэрэг 47.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, хүнсний материал үлдэгдлийн хадгалалт хамгаалалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжүүлэн ажиллаж, давтаг гаргаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дэлгэрэнгүй үзэж чадаагүй учраас гүйцэтгэлийн аудитаар үзэх шаардлагатай

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 68.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8.7 сая төгрөгийн зөрчилд залруулга хийж, 59.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Үр дүнгийн тайлангийн хөрөнгийн санхүүжилтэд тусгасан 8.7 сая төгрөгийн алдаанд залруулга хийсэн.

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй.

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Акталсан хөрөнгийн данснаас хасах, устгалт тайлагналтай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 123 дугаар тогтоолоор 29.8 сая төгрөгийн, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 54 дугаар тогтоолоор 303 төрлийн 29.9 сая төгрөгийн хөрөнгийг актлах тухай зөвшөөрөл олгосон боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргуулаагүй, байгууллагын даргын шийдвэрээр акталж, устгал хийгээгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг баримталж акталсан хөрөнгөд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулж, устгалтын акт үйлдэж баримтжуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаанхус сумын хүүхдийн цэцэрлэг	2	68.4	1	8.7					1	59.7